

**ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 10 ДУГААР АЛБАН ДААЛГАВРЫН
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

2026.06.29

Тус төв Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10 дугаар албан даалгаврын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.


1. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- 1.1. Захирлын 2026 оны А/25 тоот тушаалаар “ЭХЭМҮТ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам”-ыг батлуулав.
- 1.2. **“Эмнэлгийн орчны аюулгүй байдлыг хангах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдлийг арилгах тухай”** Захирлын 2026 оны 06 сарын 02-ны өдрийн 100 дугаар тушаалыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. Эмнэлгийн гадаад болон дотоод эрсдлийг илрүүлэх, арилгах чиглэлээр:

- 2.1. ЭХЭМҮТ-ийн Дэмжих үйлчилгээний ажилчдын баярыг тохиолдуулан **2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдрийн хүртэл 1 сарын хугацаатай “Эрсдлийг илрүүлж – Аюулгүй байдлыг хангая” аяныг** нийт тасаг нэгжийн дунд зарлав.
- 2.2. **2026 оны 05 дугаар сарын 30-ны өдөр** Захирал Ж.Отгонбаатар, Үйл ажиллагаа төлөвлөлт эрхэлсэн дэд захирал Э.Бямбасүрэн, Хүүхдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Л.Ганбаяр, Эрсдэлийн менежер С.Дуламжав, Чанарын албаны дарга А.Оюунчимэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажилтан Э.Өлзийжаргал, Хангамж үйлчилгээ, инженер техник хоол үйлдвэрлэлийн албаны дарга Э.Лхагвасүрэн, ХАБЭА мэргэжилтэн Д.Луумаа, Ерөнхий инженер С.Эрдэнэчимэг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгууллагын гадаад орчин, 8 байрилга байгууламжийн 56 тасаг нэгж, барилга хоорондын галерей гэх мэт бүх газруудаар обходоор явж эрсдлийг илрүүлэв.







- 2.3. Удирдлагын багийн тойрон үзлэгээр илэрсэн эрсдэлийг арилгахаар Эрсдлэлийн менежер С.Дуламжав, ХАБЭА мэргэжилтэн Д.Луумаа нар “Эрсдлийг илрүүлж – Аюулгүй байдлыг хангая” аян болон МУ-ын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгаврын хүрээнд нийт тасаг нэгж, албадын дарга нарт эрсдлийг арилгах тухай зөвлөмжийг хүргүүлсэн.

**ТӨВИЙН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, АЮУЛ ОСЛООС СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Өнөөгийн нөхцөл байдал, илэрсэн дутагдал	Засаж залруулсан хариу арга хэмжээ	Хэрэгжилтийн биелэлт
1.1	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 5.2.1. Гадаад орчин болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд гэрэлтүүлэг сайн байх, явган зам эвдрэл, гэмтэлгүй, нүх завсар, тор онгорхойгүй байх, хашлага тохиромжтой өндөртэй байх, өгсөх уруудах гадаргуу тусгай тэмдэглэгээтэй байх, явах гадаргууд тээглэж болзошгүй саад болох биетгүй байх	1.Хүүхдийн зөвлөх поликлиник: Тасгийн урд талын цэцгийн мандалыг ашиглаагүй байсан. 4 давхрын рентген өрөөний хажууд коридорын цонх хашлага, хаалт байхгүй. Нүднээс далддуу газар тул хүүхэд унах эрсдэлтэй Өмнө нь: 	1.Хүүхдийн зөвлөх поликлиник: - Гадна талд Цэцгийн мандалд “Гацуур мод цэцэг “суулгаж гэрэлтүүлэг хийсэн. 4 дүгээр давхрын коридорт шал цэвэрлэх үед ашиглах “Хальтирч болзошгүй” анхааруулах зөөврийн тэмдэг байгаагүй тул шаардлагатай тэмдгийг байршуулсан. Мөн 4 дүгээр давхрын рентген өрөөний хажууд коридорын цонх хамгаалалтын хаалтгүй байсан нь хүүхэд болон асран хамгаалагчид унах эрсдэл үүсгэж болзошгүй байсан тул хамгаалалтын хаалт суурилуулж эрсдэлийг арилгасан. Дараа нь: 	100%

		Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг: • Үйлчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ авах явцад эрсдэлгүй байх зорилгоор гадаад орчны тойрон үзлэг тасгийн хамт олон 2026 оны 6 сарын 9 нд хийж тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам өгсөх уруудах гадаргуу тусгай тэмдэглэгээгүй, өгсөх хэсэгт хог шороо болсон байсан хэсгийг илрүүлсэн. Хүүхдийн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасаг 1. Гэрэлтүүлэг тавих 2. Гадна шатыг цэвэрхэн байлгах . 3. Шатны тэмдэглэгээ тавих 4. Цацруулагчтай тэмдэглэгээ хийх 5. Хашлаганы төмрүүдийг холдуулах 6. ЯТТ-ийн гадна цонхны доор байгаа том нүхний хогийг цэвэрлэж, хаалт хийх 7. Хашлага хийх 8. Эмнэлгийн орчинд камертай гэсэн тэмдэглэгээ тавих, тамхи татахыг хориглох тэмдэглэгээ хийх 9. ХЭ-ЯТТ-ийн бүх цонхонд хаалт хийх 10. 103-ийн машин орох хэсэгт явган хүн явахыг болон Машин тавихыг хориглох анхааруулах тэмдэг тавих . 11. Машин тавих хэсэгт задгай утас, кабель байна.	Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг : • Өгсөж уруудах хэсэгт цэвэрлэгээ хийж талбайг бохирдол саадгүй болгож, тэмдэглэгээ хийж тавьсан. 3.Хүүхдийн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасаг: • Яаралтай тусламжийн тасгийн гадна орчныг бүх ажилчид цэвэрлэсэн. • Шатны тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан. • Хашлаганы төмрүүдийг холдуулсан. • Яаралтай тусламжийн тасгийн гадна цонхны доор байгаа нүхний хогийг цэвэрлэж хаалт хийсэн. • Машин тавихыг хориглосон тэмдэг тэмдэглэгээг байршуулсан. • Хаалганы шилэнд харааны түвшинд “ШИЛ МӨРГӨХӨӨС БОЛГООМЖИЛ” гэсэн тэмдэг тэмдэглэгээг наасан. 6.Яаралтай тусламжийн тасгийн Тусгааралах өрөө, үзлэг, ажилбарын 09,10,11,12,13,14,15,21 дугаартай өрөөнүүдийн бүх ширээний өнцөг болон өрөөний бариуланд зөөлөвч хийсэн. 7.Тасгийн тусгааралах өрөө, үзлэг, ажилбарын 09,10,11,12,13,14 ,15,21,дугаартай өрөөнүүдийн бүх хаалганд мөргөж гэмтэхээс сэргийлсэн тэмдэг тэмдэглэгээг наасан.	
--	--	--	---	--

12. СУ – дэлгүүрийн арын төмөр
тагтай нүхэнд тэмдэглэгээ тавих
13. Шил байгаа бүх хэсэгт хараа
түвшинд
“**ШИЛ МӨРГӨХӨӨС БОЛГООМЖИЛ**”
гэсэн тэмдэглэгээ наах
Өмнө нь:



Нүдний мэс заслын тасаг:

- НМЗТ-ийн гадаад орчны үнэлгээ хийхэд тасгийн эргэлтийн хаалганы шат бохир, хальтирч унах эрсдэлтэй байв.

Дараа нь:



Нүдний мэс заслын тасаг:

- ✓ Хэрэгжилтийг хангах зорилгоор тасгийн гадаад дотоод орчинд хийсэн үнэлгээний дагуу шатан дээр халтирч унахаас сэргийлж халтирахгүй наалт нааж унах эрсдэлийг бууруулсан.

1.2	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 5.2.1. Нийтийн талбай хүн зорчиход чөлөөтэй, цэвэрхэн байх, явган хүний зам талбай харааны бэрхшээлтэй зорчигчид зориулсан таягны даяллаар мэдрэгдэх хавтан суулгасан байх	Төвийн гадна талбайд нийт 75 худаг байгаас бохирын 58 дээврийн ус зайлуулах дренажийн 17 худаг байна. Эдгээрээс 22 худгийг өглөө бүр тогтмол сэрээдэж, цэвэрлэгээ үйлчилгээ хийдэг. Нийт худгийн тагны бүрэн бүтэн байдал болон хийцлэлийг ангилаж үзвэл • Үйлдвэрийн ширмэн тагтай 32 • Полимер буюу хуванцар тагтай 11 • Хоёрдогч түүхий эд (бетон цутган хийсэн болон хаягдал төмөр)-өөр ашиглан хийсэн • Гараар хийсэн төмөр таг Одоо байгаа нь: 	Төвийн хэмжээндээ ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, БНбд 3,05,04-90 “Гадна ус хангамж, ариутгах татуургын байгууламж” Гадна шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний стандартын дагуу ЭХЭМҮТ-ийн гадна талбайд болон явган хүний зам дээр байрлах ариутгах татуургын худгуудын шаардлага хангахгүй байгаа бетон, мод, төмөр хавтан, дугуй зэрэг “орлуулагч” 32 ширхэг тагнуудыг яаралтай стандартын “MNS стандартын шаардлага хангасан ширмэн болон полимер” тагаар сольж, шинэчлэн аюулгүй байдлыг хангаж ажиллахаар шинээр 32 ширхэг стандарт таг захиалсан. Захиалсан нь:	100%
-----	---	---	--	------

				
1.3	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 5.2.2. Шатны гишгүүр жигд өндөртэй, ирмэг нь эмтэрхий бус, шат нь бариултай, эхлэл, төгсгөлийг өнгөөр ялгаж тэмдэглэсэн байх	1.ЭХЭМҮТ-ийн хуучин онгоцны буудлаас Захиргаа явах замын налуу хэсэгт шат байхгүй байсан. Ард иргэд налуу шороогоор өгсөж, бууж унах эрсдэлд үргэлж орж байдаг. Өмнө нь:	1.Хөдөлгөөний их урсгалтай энэ хэсэгт унах эрсдэлд оруулахгүйн тулд 7 гишгүүртэй шат угсарч суурилуулсан. Дараа нь:	100%



Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг:

- Шатны гишгүүр жигд өндөртэй, ирмэг нь эмтэрхий бус, шат нь бариултай боловч эхлэл, төгсгөлийг өнгөөр ялгаж тэмдэглэл байхгүй.
- ЭХЭМҮТ-ийн хуучин онгоцны буудлаас Захиргаа явах замын налуу хэсэгт шат байхгүй байсан. Ард иргэд налуу шороогоор өгсөж, бууж унах эрсдэлд үргэлж орж байдаг.

Лабораторын тасаг:



Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг:


- ✓ Үргүйдэл нөхөн үржихүйн тасгийн ажилбарын хэсгийн шатны өгсөх уруудах эхлэл, төгсгөлийг өнгөөр ялгаж тэмдэглэл хийв.

Лабораторын тасаг:

- ✓ Гадна орчины буюу баруун, зүүн шатны хэсгийн эрсдэл бүхий

- Гадна орчины буюу баруун болон зүүн талын шатны хэсгийн эрсдэл бүхий хэсгүүдэд халтирч унахаас сэргийлсэн зориулалтын халтиргааны наалт наах.
- Шат бүрийн хажуу хананд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулах


Өмнөх нь:




хэсгүүдэд халтирч унахаас сэргийлсэн зориултын наалт байршуулсан.


- ✓ Шат бүрийн хажуу хананд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан.
- ✓ лабораторийн дотоод орчиндоо аюулгүй байдлыг хангах, унах осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шилэн хаалган дээр анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулж, шалны халтиргаа үүсэх эрсдэлтэй хэсгүүдэд “халтирч унахаас болгоомжилно уу” гэсэн анхааруулах наалт наасан. мөн үүдэн хэсэгт халтиргаанаас сэргийлсэн зориулалтын шалны дэвсгэр байршуулж, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн.

Дараа нь:



				
1.4	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 5.2.5. Явган зам талбайн хавтан эвдрэл гэмтэлгүй, гулсамхай бус, овон товонгүй жигд тавигдсан, ус шалбааг тогтохгүй, мөстөж гулсахааргүй байх	Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг • Явган зам талбайд тогтсон ус шалбаагт хальтарч унах эрсдэлтэй гөлгөр байв. • Төвийн хашааны зүүн талын орох хаалганы хэсэгт явган хүн зорчих хэсэг нь хаалт хашилт, тэмдэг тэмдэглэгээгүй тул явган хүмүүс машин орох хэсгээр явдаг Өмнө нь:	Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг ✓ Гаднах хэсгийн явган шатны гулсаж халитрахаас сэргийлэн резинэн арзгар гадаргуутай өнгөт дэвсгэр авч байршуулсан. ✓ Төвийн инженерын ажилчид болон орох хаалганы хүнсний мухлагийн түрээслэгч нар хамтран хамгаалалтын хашаа, явган хүн зорчих тэмдэг, шатанд бариул хийж будаж зассан. Дараа нь:	100%

				
1.5	Цахилгааны болон усан хангамж, хийн шугам сүлжээнд үзлэг хийж, аюулгүй байдлыг хангах	• Техникийн өрөөний цахилгааны нөөц үүсгүүрийн хадгалагч хэсэг дохиолол дуугарч байсан. • Тасгуудын цахилгаан болон сүлжээний утас эмх цэгцгүй, хөлд тээглэх, тогонд цохиулах эрсдэлтэй Өмнө нь: 	✓ Цахилгааны инженер болон няравт танилцуулж засвар үйлчилгээг хийлгэсэн. ✓ Тасаг хариуцсан няравууд цахилгаанчинтай хамтарч эмх цэгцтэй болгосон. Дараа нь: 	100%

1.6	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 6.2, 6.3 Орц, гарцын чиглэлийг тодорхой, гэрэлт хаягжуулалттай болгох	Хүүхдийн эмнэлгийн Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг нь засвартай байгаа тул Хүүхдийн зөвлөх поликлиникийн 1,2-р давхарт байрлаж байгаа тул орц гарцын тэмдэглэгээ байхгүй. Өмнө нь: 	Хүүхдийн эмнэлгийн Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг нь засвартай байгаа тул Хүүхдийн зөвлөх поликлиникийн 1,2-р давхарт байрлаж байгаа тул орц гарцын тэмдэглэгээ хийсэн. Дараа нь: 	100%
1.7	Зайлшгүй шаардлагатай хаалт, хашлагыг харааны түвшинд хийж, аюулгүй байдлын цацруулагч материал, наалт ашиглах	1.Төвийн ахуйн хог хаягдлын цэгийн гадна талбайд машин зогсоол дээр байдаг учир машин хааж зогсдог нь үйлчлэгч нар хогоо хаях боломжгүй, машинд мөргүүлэх, хүний машин сэвтүүлэх шалтаг шалтгаан болдог. Өмнөх нь:	1.Хогийн цэгийг хаасан хашаа хайстай болгож хогийн машин орох хэсгийн хонхорхойг бетондож орох гарах боломжийг бүрдүүлж үйлчлэгч нарын аюулгүй байдлыг хангасан. Дараа нь:	100%

		 Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг • Үргүйдэл нөхөн үржихүйн тасгийн гадна талбайн В1 давхарт орох хаалга шатны анхааруулах тэмдэглэгээ байхгүй байсан.	 Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг: ✓ В1 давхарт орох хаалга шатны хэсэгт үйлчлүүлэгчид орохоос сэргийлэн анхааруулах тэмдэглэгээ байршуулж сэрэмжлүүлэв.	
2.1	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 5.2.3, 5.2.5. Шалны плита, хулдаас, модон шал овон товон, ан цавгүй байх хулдаас, дэвсгэр хөдөлгөөнгүй, нягт бэхлэгдсэн, уранхай, цоорхойгүй байх	Төвийн хэмжээнд Архивын зарим өрөөнд эрсдэлийн үнэлгээ хийж аюулгүй байдлын анхааруулга, тэмдэг тэмдэглэгэ байршуулах Яаралтай тусламжийн тасгийн Хаалга болон ширээ, тавиурны өнцөг мөргөж гэмтэх	Төвийн хэмжээний архивуудын өрөөнүүдэд Унах эрсдлээс сэргийлж, Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн В1 давхарт байрлах №2, №5 өрөөнүүдэд гишгүүр хийсэн. Мөн гишгүүрүүдэд халтирахаас сэргийлж хамгаалалтын шалавч дэвссэн. • Яаралтай тусламжийн тасгийн Тусгааралах өрөө, үзлэг, ажилбарын 09,10,11,12,13,14,15,21 дугаартай өрөөнүүдийн бүх ширээний өнцөг болон өрөөний бариуланд зөөлөвч хийсэн.	95%

		Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг: • ҮНҮТ-ийн үйлчлүүлэгчийн хэсгийн шал цэвэрлэгээ хий явцад унаж бэртэх эрсдэл байсан • Дааврын шинжилгээ авах хэсэгт цахилгааны утас шалан дээр байршиж хөлд татагдах эрсдэлтэй байв. ЭХЭМҮТ-ийн 2026 оны 05 дугаар сарын 23 өдрийн тасаг нэгж бүрд “Эрсдэлийг илрүүлж- аюулгүй байдлыг хангая” аяны хүрээнд хийсэн тасаг бүрийн хийсэн ажил Радиологийн тасгийн Цацрагийн тэмдэг байхгүй. Жирэмсэн хүнд аюултай тэмдэг байхгүй. • Харалт хэсгийн шат бага насны болон нярайн хүүхэд хүрдэггүй тул сандал тавих шаардлага гардаг , одоо ашиглаж байгаа сандал энгийн сандал тул 2 талд түшлэгтэй сандал хийх шаардлагатай байна. • Яаралтай тасгийн Цахилгаанд цохиулах аюулыг тодорхойлж арга хэмжээ авсан	• Тасгийн тусгааралах өрөө, үзлэг, ажилбарын 09,10,11,12,13,14 ,15,21,дугаартай өрөөнүүдийн бүх хаалганд мөргөж гэмтэхээс сэргийлсэн тэмдэг тэмдэглээг наасан. Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг: ✓ Үйлчлэгч цэвэрлэгээ хийхдээ анхааруулга тэмдэглэгээ ашиглах боломж нөхцлийг бүрдүүлэн анхааруулах тэмдэг тэмдэглэгээг худалдан авч тогтмол ашиглаж хэвшсэн. ✓ Дааврын өрөөний цахилгааны утсыг дээшлүүлэн хөлд өртөхөөргүй газар байршуулж тогтоосон. Радиологийн тасгийн ✓ Цацрагийн аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах чиглэлээр: ✓ Илэрсэн зөрчлийг арилгаж, шаардлагатай анхааруулах болон аюулын тэмдэг тэмдэглэгээг бүрэн байршуулсан. ✓ Мөн хүүхэд унаж бэртэх эрсдэлийг бууруулах зорилгоор хоёр рентген өрөөнд хоёр талдаа түшлэгтэй зориулалтын сандал байрлуулах ажлыг зохион байгуулсан. ✓ 2ш шинэ сайжруулсан сандал хийлгэхээр захиалсан байгаа.	
--	--	--	--	--

2.2	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 5.2.3. Цахилгааны утсыг явах гадаргууд ил болон шалны дэвсгэр, хулдаасны доогуур овойлгон хийхгүй, бөгөөд хөлд тээглэхээргүй хананы ирмэгээр бэхлэн тогтоосон байх	Радиологийн тасгийн • 404 тоот рентгений өрөөнд хуучин тоног төхөөрөмж зөөн байрлуулсан тул цахилгааны утас аргагүй шаардлагын улмаас шалан дээгүүр ил байна. • Тасгийн бусад хэсэгт ил хөлд тээглэхээр зүйл байхгүй. Өмнө нь: 	Радиологийн тасгийн ✓ Цахилгааны утас, кабелийн байрлалд үзлэг хийхэд стандартын шаардлага хангаж байсан бөгөөд хөлд тээглэх, бүдрэх эрсдэл илрээгүй. ✓ Төвийн хэмжээнд В1 давхарт байрлах эмнэлгийн архив №1 өрөөнд бүрэн засвар хийж ус алдахаас сэргийлэн цэвэр бохир усны шугамыг хулсан хавтангаар хаалт хийлгэсэн. Мөн паркетан шалыг сайжруулж хулдаас дэвссэн Дараа нь: 	95%
2.3	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 5.2.5. Шал	Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг • ҮНҮТ-ийн үйлчлүүлэгчийн хэсгийн шал цэвэрлэгээ хийх явцад унаж бэртэх эрсдэл байсан. Радиологийн тасгийн	Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг ✓ Үйлчлэгч цэвэрлэгээ хийхдээ анхааруулга тэмдэглэгээ ашиглах боломж нөхцлийг бүрдүүлэн анхааруулах тэмдэг авч тогтмол ашиглаж хэвшсэн.	90%

	нойтон үед халтирах аюултай тул цэвэрлэгээ хийх үед анхааруулах тэмдэг тэмдэглээ байрлуулах	• 4 давхрын коридорын шал угаахад халтирахаас болгоомжил зөөврийн тэмдэг байхгүй. • Мөн 4 давхрын рентген өрөөний хажууд коридорын цонх хашлага, хаалт байхгүй. • Төвийн хэмжээнд Архивын өрөөний галын аюулгүй байдлыг хангаж ажиллах	Радиологийн тасгийн ✓ 4 дүгээр давхрын коридорт шал цэвэрлэх үед ашиглах “Хальтирч болзошгүй” анхааруулах зөөврийн тэмдэг байгаагүй тул шаардлагатай тэмдгийг байршуулсан. ✓ Мөн 4 дүгээр давхрын рентген өрөөний хажууд коридорын цонх хамгаалалтын хаалтгүй байсан нь хүүхэд болон асран хамгаалагчид унах эрсдэл үүсгэж болзошгүй байсан тул хамгаалалтын хаалт суурилуулж эрсдэлийг арилгасан. ✓ Төвийн хэмжээндээ Архивын өрөөний галын аюулгүй байдлыг хангахад элсний хайрцаг 8 , цилиндр хувин 5 , хүрз 5 ширхэг дутуу байсанг бүрдүүлэн архивын өрөөнд байршуулсан. Галын аюулгүй байдлын ажиллах зааврыг ил байрлуулсан. Бүх архивын өрөөг галын булантай болгосон ✓ 2. Архивын №2, №5 өрөөнүүдийн гэрлийг стандартын бүрхүүлтэй гэрлээр шинэчилсэн.	
2.4	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 5.2.9. Хаалганы босго нам байх, яаралтай тусламжийн үед зөөврийн ор хэрэглэх, тэргэнцрээр тээвэрлэхэд саадгүй	Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг • Хаалганы босго нам биш, яаралтай тусламжийн үед зөөврийн ор хэрэглэх, тэргэнцрээр тээвэрлэхэд саадтай босго тэгшлэгч байхгүй. Өмнө нь: Хүүхдийн зөвлөх поликлиник: • Засмал замаас орох хэсэгрүү явахад хөгжлийн бэрхшээлтэй хүний зам байхгүй.	Үргүйдэл нөхөн үржихүйн тасаг ✓ Хаалганы босго нам байх, яаралтай тусламжийн үед зөөврийн ор хэрэглэх, тэргэнцрээр тээвэрлэхэд саадгүй болон бүдэрч, тээглэж унах эрсдэлийг бууруулах зорилгоор босго тэгшлэгч захилаад хүлээж байна. Дараа нь: Хүүхдийн зөвлөх поликлиник:	100%

	болон бүдэрч, тээглэж унах эрсдэлийг бууруулж, босго тэгшлэгч ашигладаг байх		СНББА-ны ажилчид санхүүжүүлж барилгачин, слесарь, цахилгаанчин нар хийж гүйцэтгэв. 	
2.5	Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандартын 5.2.9. бүдэрч, тээглэж унах, эрсдэлийг бууруулах	Нойлын өрөөнүүдийн хаалганы цоож нь гацдаг болон цоожлогдохгүй байгааг засаж янзлуулах Өмнө нь: 	Бие муутай хүүхэд болон том хүн ороод гацдаг цоожнуудыг бүгдийг сольж янзалсан . Дараа нь: 	100%
Дүн		Нийт ЭХЭМҮТ-ийн хэмжээнд гадаад болон дотоод орчны аюулыг илрүүлж яаралтай хийх аюулыг шат дараатай 100% гүйцэтгэлтэй хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Мөн манай байгууллагатай хамаатай ХХК болон аж ахуй нэгжтэй дараах байдлаар хамтран ажиллаж байна.		

2. Хүүхэд хамгааллын чиглэлээр:

2.1. Монгол Улсын Засгийн газраас эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлд онцгой анхаарч, 1200 гаруй албан хаагчтай **ЭХЭМҮТ-ийн дэргэд ажилчдын хүүхдэд зориулж 150-200 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг барих төсвийг 2023 онд Улсын төсвөөс шийдвэрлэж өгсөн. Цэцэрлэгийн шав тавих ёслол 2023 оны 05 сарын 10-ны өдөр болж, барилгын ажлыг “Тэргүүн конштракшн” ХХК гүйцэтгэж, 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр ашиглалтад оруулахаар төлөвлөж, ажлыг гүйцэтгэсэн.**

Гэвч 2024 оны 3 дугаар улиралд одоогийн байгаа **80% гүйцэтгэлд** хүрснээс хойш өнөөг хүртэл ажил дуусаагүй байгаа тул цэцэрлэгийг ашиглалтад оруулах төсвийг шийдвэрлүүлэхээр **2025 онд 3 албан бичиг, 2026 оны эхний хагас жилд 3 албан бичгийг** холбогдох газруудад хүргүүлж, уулзалт хийж байгаа ч одоогоор тодорхой шийдвэр, үр дүн гараагүй байна.

2.2. ЭХЭМҮТ-ийн ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд ажилчдын 6-10 хүртэлх насны, гэртээ бие даан байх боломжгүй, харах хүнгүй хүүхдүүдийг хамгаалах үүднээс “Өдөр өнжүүлэх төв” ажиллуулахаар судлаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Ажилчдын хүүхдийн судалгаагаар 0-3 насны 148, 4-7 насны 253, 8-12 насны 380, 13-16 насны 195, 16-18 насны 125 хүүхэд байна. “Өдөр өнжүүлэх төв”-ийг ҮЭХ-той хамтран тохижуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2.3. МУ-ын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10 дугаар албан даалгаврын хүрээнд Захирлын 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай” А/98 тоот тушаалаар эцэг эхийн зөвлөлийг байгуулж, зөвлөлийн ажиллах журам, хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

2.4. Азийн сангаас “Үлгэр уншъя” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2026 оны 06 сарын 25-ны өдөр ЕМЗТ-т хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдэд үлгэр уншиж, хамтдаа хөгжилдөв. Цаашид сардаа 2 удаа энэхүү үйл ажиллагааг зохион байгуулна.

2.5. Хүүхдийн зөвлөх поликлиникин 5 давхарт болон хүүхдийн тасгуудад хүүхэд тоглох талбайг тохижуулсан байдаг.

ТАЙЛАН БИЧСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА Б.МӨНХШҮР